НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 09 дугаар сарын 12 Дугаар А/154 Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны
төсвийн хуваарь батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь заалт, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13.1, 37.14.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарь”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарь”-ийг хоёрдугаар хавсралтаар, “Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн сар, улирлын хуваарь”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус өөрчлөн баталсугай.

2.Төсвийн санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу олгохыг Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар (Б.Алтанцэцэг)-т, төсвийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газарт тус тус даалгасугай.

3.Баталсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, төсвийн сахилгыг ханган ажиллахыг нийгмийн даатгалын байгууллагуудын төсвийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн “Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/80 дугаар тушаал, 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн “Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/106 дугаар тушаал, 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн “Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/130 дугаар тушаал, 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн “Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/141 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар (Б.Ганхуяг)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНЦЭЦЭГ

9024020135 СТС4666 9081739

1524011054

